



184

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

Г
Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц, дүрмийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллахыг тус Төв /М.Нямсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуюяа/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 271 дүгээр тушаалын нэг, хоёрдугаар хавсралт болон гуравдугаар хавсралтын 4.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 11 сарын 01 өдрийн
404 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

185

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зоонозын өвчин судлалын үндэсний төв (цаашид Төв гэх) нь улсын хэмжээнд зоонозын өвчний тусlamж, үйлчилгээг сургалт, эрдэм шинжилгээ, судалгаатай хослуулан мэргэжил, арга зүйгээр хангаж, мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх чиглэлээр лавлагaa төвийн үүрэг гүйцэтгэх мэргэжлийн байгууллага мөн.

1.2. Төв нь улсын хэмжээнд хүн амд зоонозын өвчний хяналт, сэргийлэлт, тандалт, оношилгоо, эмчилгээний лавлагaa тусlamж, үйлчилгээ үзүүлэх, стандарт, эмнэлзүйн удирдамж, аргачлал боловсруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, судалгаа шинжилгээний ажил эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллага болно.

1.3. Төв нь Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Төрийн тусгай хамгаалалт бүхий онцгой объект болно.

1.4. Төв нь байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна.

1.5. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журмын дагуу явуулна.

1.6. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас болон билэгдэл, санхүүгийн харилцах данстай байна.

1.7. Төв нь Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Улаанбаатар хот 18131, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо гэсэн хаягтай байна.

1.8. Төвийн нэрийг англи хэл дээр "National Center for Zoonotic Diseases" гэж нэрлэнэ.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих;
- Тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
- Тусlamж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;
- Тусlamж, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь дараах эрхтэй:

3.1.1. Зоонозын өвчний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэлзүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл, эрдмийн болон мэргэжлийн зэрэг, ур чадварын болон бусад нэмэгдлийг зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу олгож, захиран зарцуулах;

3.1.3. Ижил чиг үүрэг бүхий гадаадын лавлагаа төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;

3.1.4. Судалгаа шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах;

3.1.5. Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах;

3.1.6. Тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх;

3.1.7. Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.8. Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүсгэж болзошгүй үед шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хувь хүнээс гаргуулах;

3.1.9. Зоонозын өвчний асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран шинжээчийн багийг томилж, магадлагаа, дүгнэлт гаргах;

3.1.10. Байгууллагын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаад, дотоодын эмч, мэргэжилтнүүдэд байгууллагын дотоод журмын дагуу "Хүндэт тэмдэг" олгох, "Хүндэт дэвтэр"-т бичиж алдаршуулах, "Хүндэт профессор" цолоор өргөмжлэх;

3.1.11. Аймаг, нийслэл дэх Зоонозын өвчин судлалын төв (цаашид ЗӨСТ гэх)-ийн даргыг томилох, чөлөөлөх асуудлаар харьяалах Эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцэх;

3.1.12 ЗӨСТ-ийг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах;

3.1.13. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх;

3.2. Төв нь дараах үүрэгтэй

3.2.1. Зоонозын өвчний чиглэлээр оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, аргачлал, бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тусламж үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний санал боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

3.2.2. Зоонозын өвчний тусламж, үйлчилгээнд олон улсын болон Монгол улсад мөрдөгдэж буй хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөж ажиллах;

3.2.3. "Нэг дэлхий-Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалын хүрээнд зоонозын өвчний чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг удирдан зохицуулж ажиллах;

3.2.4. Гамшгаас хамгаалах, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.5. Зоонозын өвчний чиглэлээр төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан ажлын байрны болон зайн сургалт явуулах, шаардлагатай материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх;

3.2.6. Эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжлийн зэргийн шалгалт болон гадаад, дотоодын магистрантур, докторантурын сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх;

3.2.7. Тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

3.2.8. Үйл ажиллагаандaa мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим бүртгэлийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

3.2.9. Зоонозын өвчний тандалт, сэргийлэлтийн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэж, бодлогын баримт бичгийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох;

3.2.10. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, дунд хугацааны стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;

3.2.11. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;

3.2.12. Зоонозын өвчний асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх, суурь судалгааны сэдэвт ажил, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан судалгаа, шинжилгээ хийх;

3.2.13. Үндэсний болон олон улсын хэмжээнд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, оролцох;

3.2.14. Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөцийн хадгалалт, зарцуулалт, нөхөн хангалтын арга хэмжээг зохион байгуулах;

3.2.15. Халдварт өвчний ариутгал, халдвартгүйтгэл, мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

3.2.16. Үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

3.2.17. Тусlamж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, санал гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг үйл ажиллагаандaa тусган ажиллах;

3.2.18. Үзүүлж буй лавлагаа тусlamж, үйлчилгээний чиглэлээр олон улсын түвшний итгэмжлэл авсан байх;

3.2.19. Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит, нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн үр ашигтайг нь сонгон санхүүжүүлдэг байх;

3.2.20. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

3.2.21. Ажиллагсдын мэдлэг, үр чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

3.2.22. Зоонозын өвчин үүсгэгчдийн өсгөвөр омог; эерэг сорьцын санг бүрдүүлэх;

3.2.23. Зоонозын өвчний лабораторийн оношилгооны биобэлдмэл үйлдвэрлэх, ханган нийлүүлэх;

3.2.24. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг;

Дөрөв. Төвийн бүтэц, зохион байгуулалт

4.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь Захирал, түүний дэргэдэх Захиргааны болон Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.

4.2. Төвийн захирал нь дэд захирал болон нэгжийн удирдлагуудыг оролцуулсан Захиргааны зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

4.3. Төв нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Төвийн захирал батална.

4.4. Төвийн захирал нь тушаал, Захиргааны зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.

4.5 Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Санал гомдлын хороо болон бусад шаардлагатай хороод байгуулан ажиллуулна.

4.6. Төвийн захирлын эрх, үүрэг

4.6.1. Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

4.6.2. Төвийн бүтэц, алба, тасгийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлох, байгууллагын дотоод журам, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, ойрын болон хэтийн хөгжлийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

4.6.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

4.6.4. Дэд захирал, албаны дарга, тасгийн эрхлэгч нарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төмилөх, чөлөөлөх;

4.6.5. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг хамт олны хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

4.6.6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, гэрээг цуцлах;

4.6.7. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр Төвийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;

4.6.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах;

4.6.9. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах;

4.7. Төвийн дэд захирлын эрх, үүрэг

4.7.1. Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг Захирлын удирдлаган дор зохион байгуулах;

4.7.2. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр болон эрхзүйн баримт бичгийн хүрээнд байгууллагын эрхлэх үндсэн чиг үүргийг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх, хяналт тавих;

4.7.3. Төвийн бүтэц, алба, тасгийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн хөгжлийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих;

4.7.4. Төвийн захирлын эзгүйд орлон ажиллах.

Тав. Төвийн санхүүжилт

5.1. Улсын төсөв;

5.2. Үндсэн (төлбөртэй тусlamж, үйлчилгээний орлого) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, бусад хууль тогтоомжид нийцүүлэн олсон орлого гэх мэт);

5.3. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж;

5.4. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.5. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Зургаа. Гадаад, дотоод хамтын ажиллагаа

6.1. Төвийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд Төвийн захирал төлөөлнэ.

6.2. Төвийн захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

6.3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Төвийн захирал шийдвэрлэнэ.

6.4. Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга настай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

6.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Долоо. Төвийн алба, тасгийн өрөнхий чиг үүрэг

7.1. Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн алба

7.1.1. Төвийн алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого шийдвэртэй нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх;

7.1.2. Хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах, байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах;

7.1.3 Байгууллагын дотоод журам, эрсдэлийн үеийн журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

7.1.4. Төвийн чиг үүргийн хүрээнд хамрах асуудлын чиглэлээр үндэсний хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг манлайлан зохион байгуулах;

7.1.5 Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, төлөвлөгөө гарган хангарт, хуваарилалт, байршуулалт хийх, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, чадавхижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, багц цагийн баталгаажуулалт хийх, ажилтнуудын хувийн хэрэг, мэдээний санг хөтлөх, тогтмол баяжилт хийх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, албан хаагчидтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлж ажиллах, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

7.1.6 Байгууллагын барилга, эд хогшил, автомашин, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, гадаад болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хийх;

7.1.7. Архив, бичиг хэргийн үйл ажиллагааг стандартын дагуу хэрэгжүүлж, хадгалалтын нөхцлийг бүрдүүлэх.

7.2. Тандалт судалгааны алба

7.2.1. Зоонозын өвчний эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээний бодлого, чиглэлийг тодорхойлж, үндэсний хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах;

7.2.2. Зоонозын өвчний үйл явдалд болон шалгуур үзүүлэлтэд суурилсан тандалт, судалгааг зохион байгуулж, байгалийн голомтын болон хүн амын дундах эрсдлийн түвшин, тархалтыг тогтоох;

7.2.3. Зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

7.2.4. Зоонозын өвчний хүн, мал эмнэлгийн салбар хоорондын зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд мэдээ, мэдээлэл солилцох, хамтарсан тандалт судалгаа хийх, эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулах;

7.2.5. Эмнэлгийн мэргэжилтний чадавхийг сайжруулж, онолын болон дадлагажуулах, зайн сургалтуудыг зохион байгуулах;

7.2.6. Мэдээний сан үүсгэх, олон улсад нэвтэрч буй анагаах ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах;

7.2.7. Улсын хэмжээнд зоонозын өвчний статистик мэдээг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, нэгтгэх, тайлагнах, мэдээний сан үүсгэх;

7.2.8. ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдэд бүртгэл, мэдээллийн сургалт хийх, хяналт тавих, цахим бүртгэл, алсын зайн технологийг нэвтрүүлэх;

7.2.9. Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөцийн ашиглалт, зарцуулалтыг хариуцан зохион байгуулж, хяналт тавих;

7.2.10. Судалгаа, шинжилгээний шаардлага хангасан лабораторийн туршилтын амьтнаар хангах.

7.3. Лавлагаа лабораторийн алба

Лавлагаа лабораторийн алба нь үндэсний хэмжээнд тарваган тахал, boom, галзуу, хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиоз, хумхаа, бруцеллёс зэрэг зоонозын халдварын лавлагаа лабораторийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

7.3.1. Зоонозын өвчний эмнэлзүйн, тархвар судлалын, гадаад орчны, халдварын агуулагч, дамжуулагч амьтдын болон биотерроризмын холбогдолтой сорьцод лабораторийн лавлах шинжилгээ хийх, үр дүнг баталгаажуулах;

7.3.2. Лабораторийн шинжилгээ, оношилгооны лавлах технологи, стандарт үйлдлийн аргачлалыг боловсруулах, харьцуулан үнэлэх;

7.3.3. Лабораторийн шинжилгээний тэжээлт орчин, биобэлдмэл үйлдвэрлэлийн чанар, стандартчлалыг хангах, технологийг шинэчлэх;

7.3.4. Лабораторийн чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх;

7.3.5. Лабораторид суурилсан тандалт судалгааг гүйцэтгэх;

7.3.6. Лабораторийн туршилт, үйлдвэрлэл явуулах;

7.3.7. Мэргэжлийн сургалт явуулах, хүний нөөцийг бэлтгэх;

7.3.8. Лабораторийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

7.3.9. Зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омог (нян, вирус, эгэл биетэн), зэрэг сорьц (эсрэгтөрөгч, эсрэгбие)-ыг баталгаажуулах, өсгөвөр, зэрэг сорьцын сан ажиллуулах, баяжуулах;

7.3.10. Лабораторийн биохамгаалал, биоаюулгүй байдал, биобитүүмжлэл, хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийн стандарт шаардлагыг хангах;

7.3.11. Зоонозын өвчний ариутгал, халдвартгүйтгэл, хог хаягдал, шимэгчгүйтгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх;

7.3.12. Аймаг, нийслэл дэх ЗЭСТ-ийн лабораторид лавлагаа үйлчилгээ үзүүлэх, Үүнд:

- Лабораторийн тусламж, үйлчилгээний нэгдсэн бодлого чиглэлээр хангах;
- Лабораторийн чанарын хяналтын тогтолцоонд хамруулах;
- Лабораторийн хүний нөөцийг мэргэжлийн сургалтаар хангах;
- Зоонозын өвчний лабораторийн онош зүйн тусламж, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үр дүнг баталгаажуулах;
- Байгалийн голомтын болон хүн амын дундах лабораторид суурилсан тандалт судалгааны үр дүнг баталгаажуулах;
- Лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн хангалт, хэрэгцээг тодорхойлох;
- Оношуур, урвалж, тэжээлт орчны хэрэглээ, зарцуулалтад хяналт тавих, зөвлөгөө өгөх, ханган нийлүүлэх;
- Лабораторийн нэгдсэн бүртгэл, мэдээллээр хангах;
- Лабораторийн тусламж, үйлчилгээнд хяналт-үнэлгээ хийх, зөвлөгөө өгөх.

7.4. Судалгаа шинжилгээ, сургалт, технологийн алба

7.4.1. Зоонозын өвчний чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, зөвлөмж боловсруулах, судалгааны мэдээний сан үүсгэх;

7.4.2. Олон улсад нэвтэрч буй анагаах ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах, гадаад харилцааг өргөжүүлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр боловсруулан харилцан туршлага солилцох, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах;

7.4.3. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн ажилтнуудын ажлын байран дах, зайн болон төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эрүүл мэндийн чиглэлээр эмч мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтарч ажиллах.


7.5. Чанар, хяналт, үнэлгээ, дотоод аудитын тасаг

7.5.1. Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, эмнэлзүйн эрсдэлийн бэлэн байдлыг үнэлэх, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, ил тод, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж, чиглэл гаргах;

7.6 Санхүү бүртгэлийн тасаг

7.6.1. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудад нийцүүлж харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангах, санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах ажлыг зохион байгуулах, эд хөрөнгийг бүртгэх, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх;


**МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН
УДИРДЛАГААР ХАНГАХ ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ**



Тайлбар:

- Мэргэжил агаа зүйн шүүб уйирлалаа
- Мэргэжил агаа зүйн шүүб бус уйирлалаа

ЗООННОЗЫН ОВЧИН СУДЛАЛЫН УНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД:
2013 ОНЫ 11 САРЫН 01 ЕДРИЙН
404 ДУГААР ХАВСРАЛТ
2 ДУГААР ХАВСРАЛТ